

**Увс аймгаас олдсон үйсэн нугалбар номын судалгаа\***

*Япон Монголын хамтарсан үйсэн дээрх  
бичгийн судалгааны баг*

**Өмнөх үг**

1999 оны 6 сард тэр үеийн Монголын ШУА–н Түүхийн хүрээлэнгийн захирал Аюудайн Очир Монголын баруун хязгаар дахь Увс аймгийн Бөхмөрөн сумын Даваагчин Улаан гэдэг газраас барьцалдан наалдсан хусны үйс бүхий хатуулаг зүйлийг олж, хатуулагийн нүүрэн тал дээрх монгол бичгийг үндэслэн, уг хатуулаг нь монголд цөөхөн олдоод байгаа “үйсэн дээрх бичиг” болохыг нь мэджээ. Эхэндээ нүүрэн тал дээрх монгол бичгийн хэлбэр болон агуулгаас нь хараад аль нэгэн бурхны шашны судар, эсвэл бурхан юм уу лам нарын магтаалыг агуулсан XVIII - XIX–р зууны үе ийн бичиг биз хэмээн таамаглаж байлаа. Гэвч хадгалалт, засварлалтын хугацаа дүүсч, барьцалдсаныг нь хуулан, уншин үзтэл энгийн нэг бичиг биш сурвалж бичиг болох нь илэрхий болсон юм. Иймд энэхүү өгүүлэлдээ дээрх материалыг бичиг гэлгүй сурвалж гэж авч үзмээр байна.

Сурвалж олдсон газрын тухайд, урьд нь суврага байсан гэх нутгийн хүний аман мэдээ байгаа боловч сурвалж, тэмдэглэл зэрэг түүхийн баримт байсан эсэх талаар өнөөг хүртэл нягтлан судалсан зүйл үгүй байна.

Монголд дээрхийн адил үйсэн хатуулагийг хадгалан, сэргээн засварлах технологи сайтар хөгжөөгүй тул\* Очир олсон зүйлийнхээ зургийг нь авч, түүнийгээ Тохокү Их Сургуулийн профессор М. Оканами–д илгээн, Японд хадгалан, сэргээн засварлах боломж байгаа эсэх талаарх зөвлөгөө хүсчээ. Оканами профессор Васэда Их Сургуулийн профессор Ж. Ёшидад санал болгосноор, 2000 оны хавраас Ёшида Очир нар уулзан, хадгалалт болон сэргээн засварлалтыг хийлгэх Японы байгууллагыг сонгон, Япон талын хөрөнгөөр дээрх ажлыг гүйцэтгэхээр болжээ. Мөн уг сурвалжийг хоёр тал хамтран судалж, судалгааны үр дүнгээ ч хамтран зарлахаар тохиролцон, 2001 оны 6 сард хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсан. Хамтарсан судалгааны багийн гишүүдээр, Японы талыг төлөөлж Ж. Ёшида, Монголын талыг төлөөлж Очир нар, түүнчлэн Васэда Их Сургуулийн багш Ю. Ишихама, багш Н. Иноүэ, МУБИС–н дэд профессор Р. Алтанзаяа нар ажиллахаар болсон. Ёшида “Монгол улсын Увс аймгаас олдсон үйсэн дээрх бичгийн хадгалалт судалгаа” хэмээн нэрийдсэн судалгааны ажлаа санхүүжүүлэхээр Шикашима Шинжлэх Ухааныг

\* Энэхүү өгүүлэл нь Японы Васэда Их сургуулийн Монгол Судлалын Төвөөс эрхлэн гаргадаг сэтгүүлийн анхны дугаар (2003 оны 4 сар)-т проф. Ёшида Жүничигийн эмхтгэснээр хэвлэгдсэн болно.

дэмжих санд хүсэлт гарган, 2000 оны судалгааны зардлыг олсон бөгөөд, 6 сарын 27-ны өдөр монголоос ирсэн эхийг 6 сарын 28-ны өдөр Гэнкёожи судалгааны төвд хадгалалт засварлалтыг хийлгэхээр өгчээ. Хадгалалт засварлалтын ажил 10 сарын эхээр дуусах байсан ч багагүй хугацаа зарцуулж, эхний хэсэг болох тал хувийг нь 11 сарын 16-ны өдөр, үлдсэн хэсгийн ихэнхийг нь 12 сарын 12-ны өдөр, сүүлчийн хэсэг болон хадгалах савыг нь 2002 оны 3 сарын 11-ний өдөр хүлээн авсан билээ. Аз болоход гэмтсэн зүйл харьцангуй бага байсан бололтой, эх маань засварлалтын дараа төсөөлж байснаас ч илүү тод цэвэрхэн, уншихад хялбар болсон байлаа.

Хадгалан засварлах ажлыг доорхи дарааллаар хийсэн болно.

1. Үйсний гадаргуу дээрх шороог багсаар цэвэрлэх ;
2. Үйсний ар талд япон цаас нааж, улам бэхжүүлэхийн тулд арьсны цавуу түрхэх ; Энэ нь хожим япон цаасыг хуулах хэрэг гарахад үсэг нь гэмтэхээс сэргийлсэн арга болно.
3. Цавуу түрхэн зөөлөрсөн үйсэнд даралт өгч нугаларсан болон гажсан хэвийг засах ;
4. Үйсний аль нэг талд нимгэн цаасыг акрилын давирхайгаар наан, ан цав болон хагарлыг зогсоон сэргийлэх ; Акрилын давирхай хэрэглэвэл үсэг нь илүү тод харагддаг.
5. Үйсний япон цаас нааж болохооргүй хэсэгт акрилын давирхай түрхэн бэхжүүлэхийн хамт ар талын өнгийг нь сэргээн тохируулах ;
6. Үйсний хэлтэрхийнүүдийг япон цаасан дээр нийлүүлэн наах ; Хэлтэрхийний хэлбэр, судал, ширхэг болон үсгийн холбоос зэргээр сэжүүр хийн эвлүүлэн наасан бөгөөд залгагдсан тасархай хэсэг 34 болсон.

Хадгалалт засварлалтын үед, хэрэглэсэн бэхний талаар задлан шинжлэгээ хийсэн бөгөөд «Улаан өнгөний тухайд таамаглаж байсан мөнгөн ус болон оохорын гаралтай бодис илэрсэнгүй, ямар бодис хэрэглэсэн нь мэдэгдэхгүй байна. Хар өнгийн үсэг нь нүүрстөрөгчийн гаралтай зүйлээр бичигдсэн байж болно» гэсэн дүгнэлт гарсан юм. (Дээрх дүгнэлт 2002 оны намар хэвлэгдсэн Шикашима Шинжлэх Ухааныг дэмжих сангийн «2001 оны мэдээлэл» сэтгүүлийн 120–123 талд нийтлэгдсэн). Шикашима сангаас 2001 онд дахин санхүүжүүлснээр эхийн судалгаа эхэлсэн. Засварлалт дууссаны дараа эхийн хэрчмийн тоо, хэмжээ зэрэгт тулгуурлан, зураг авах, агуулгыг нь судлах ажил хийснийг доор хураангуйллаа.

Нийт 149 хэрчим буйг бүрэн бүтэн байдал, үсэг бичигдсэн байгаа эсэхээр нь ялгавал:

1. Бүрэн бүтэн 47 хэрчим (ар өвөргүй бичигтэй 35 хэрчим, нэг талдаа бичигтэй 10 хэрчим, огт бичиггүй 2 хэрчим)
2. Дээрхийн талтай тэнцэх хэмжээтэй 31 хэрчим (ар өвөргүй бичигтэй 21 хэрчим, нэг талдаа бичигтэй 6 хэрчим, огт бичиггүй 4 хэрчим)
3. Жижиг хэмжээтэй 71 хэрчим (ар өвөргүй бичигтэй 37 хэрчим, нэг талдаа бичигтэй 17 хэрчим, огт бичиггүй 13 хэрчим, бичиг байгаа үгүй нь тодорхойгүй 4 хэрчим)
4. Хог хаягдал=1

Ерөнхий байдлын хувьд:

1. Үндсэн байдал

① өргөн нь 60–110мм, урт нь 80–150мм хэмжээтэй хэрчмийн зүүн талд нэлээд олон нүх гарган утсаар үдэж байсан байдалтай. Одоогийн монголын ном хэвлэлийн адил баруун талаасаа хуудсаа эргүүлнэ.

② өргөн нь 40–60мм, урт нь 155–170мм хэмжээтэй хэрчмийг хэд давхарлан голд нь нүх гарган үдэж, тэр хэсгээрээ нугалсан байдалтай. ①, ② хоюулаа үдээс нь алга болсон байна.

2. Үдээгүй хэрчим. Өргөн нь 60–80мм, урт нь 150–200мм хэмжээтэй хэрчим дээр өвөр талыг нь уншиж дуусаад дээш нь сөхөн эргүүлж, ар талыг нь уншихаар судрын хэлбэртэй бичсэн байна.

Дээрх үндсэн ажлыг дуусгаад монгол бичгээрх эхийг галиглан, тайлбар орчуулга хийснээр ерөнхийдөө ажлаа дуусгах болсон. Уг ажил нь энэхүү сэтгүүлд нийтлэгдсэн өгүүлэл болно.

Хоёр жил үргэлжилсэн Шикашима сангийн санхүүжилт 2003 оны хавар дуусч, Иноүэ Шиманэ мужийн Их Сургуулийн дэд профессороор томилогдон, Ёшида судалгааны багийн Японы талын төлөөлөгчийн албанаас татгалзан судлаач гишүүн нь болж, Иноүэг төлөөлөгчөөр сонгосон. Ийнхүү шинэ бүтцээрээ доор өгүүлэх сурвалжийн судалгааг хийхээр болсон юм. Очир 2000 оны 9 сард дахин Даваагчин Улааныг зорьж, судалгаа хийхдээ цаасан дээр бичсэн бас нэгэн сурвалжийн барьцалдан наалдсан хатуулгийг олжээ. Түүний байдал нь үнэхээр муудсан байсан тул ойр хавийнх нь шороотой хамт доогуур нь ухан авсанаас, хэдий үед бичигдсэн ямар агуулгатай бичиг болохыг таамаглахад туйлын бэрхшээлтэй байлаа. Түүнчлэн нэг нэгээр нь хуулан, уншихад бэлэн болгохын тулд маш болгоомжтой дээд зэргийн хадгалалт засварлалт шаардлагатай болох нь харагдсан. Тийнхүү энэ ажилд шаардлагатай зардалыг олохоор чармайн, Иноүэ төлөөлөгч 2003 онд Мицүбиши санд хүсэлт гарган, санхүүжилт авахаар болсон. Тэдгээр Даваагчин Улаанаас олдсон зүйлээс гадна, 2003 оны 3 сард Ёшидаг Улаанбаатарт очих үед Очир 22 хэрчим гаруй үйсэн бичгийн дурсгалыг үзүүлж, хамтарсан судалгаа хийх хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ. 15 илүү хэрчмийг нь Хар Бухын балгаснаас, 7 хэрчмийг нь Архангай аймгийн нэгэн багшаас авсан гэх эдгээр дурсгалууд нь XVI-XVII-р зууны үед бичигдсэн, шашны холбогдолтой зүйлс зонхилно гэж Очир тайлбарлаад, 6 сард дахин Хар Бухын балгас руу судалгаагаар явах төлөвлөгөөтэй буйгаа хэлсэнд Ёшида уг судалгааны үр дүнг харж байж тодорхой ярилцах хариуг өгчээ.

Мөн оныхоо 9 сарын сүүлээр Ёшида дахин ирж Даваагчин Улаанаас олдсон цаасан дурсгалын судалгааг Мицүбиши сан санхүүжүүлэхээр болсныг дуулган, Очирын хадгалж байсан хатуулгийг үзвэл, үндсэндээ бүрэн эвдрэн гэмтсэн байлаа. Уг нь хатуулгийг мэргэжилтнүүдийн хэлсний дагуу хадгалсан ч эх нь угаасаа муудсан байсан учраас ийм боллоо хэмээн таамаглагдаж байна. Энэ хэргийг сонсож гайхшралд орсон Ёшида, Мицүбиши сангаас санхүүжүүлэхээр болсон судалгааны сэдвээ даруй Хар Бухын балгасаас олдсон сурвалжийн судалгаагаар солихоор болж, 6 сарын судалгааны үр дүнг сонирхвол, урьд олдсонтойгоо нийлээд 70 орчим хэрчим болсон, дахин олдох магадлал ч байгаа гэх нь тэр. Ингээд хожуу Хар Бухын балгаснаас олдсон сурвалжийг хамтран судалахаар болж, Иноүэ рүү холбоо барин, судалгааны сэдвээ солих хүсэлт гаргуулахад, Мицүбиши сан дахин судлан үзэх нөхцөлтэйгээр хүсэлтийг хүлээн авсан билээ. Удалгүй "Монголын баруун бүсээс олдсон үйсэн дээрх дурсгал бичгийн хадгалалт, шинжилгээ ба харьцуулсан судалгаа" хэмээх судалгааны ажил маань санхүүжилт авахаар болж, Японы талыг төлөөлж Н. Иноүэ, судлаачаар Ж. Ёшида, Монголын талыг төлөөлж Очир судлаачаар Алтанзаяа нар ажиллахаар болсон юм.

Ийнхүү Даваагчин Улаанаас олдсон үйсэн дээрх дурсгал бичгийн судалгаа түр зогсож, үлдсэн судалгаа болон шинэ судалгааны ажлыг явуулах судалгааны баг өөрчлөгдсөн боловч, Ёшида өнөөг хүртэл өөрөө хариуцаж ирсэн, бусад үйсэн дээрх дурсгалууд дотроо нэлээд үнэ цэнэтэй харьцангуй гэмтэл болон дутуу хагас зүйл бага, хэлбэр болоод хэлнийхээ хувьд ч онцлогтой Даваагчин Улааны үйсэн нугалбар номны судалгааныхаа үр дүнг мэдээлэх бодолтой байлаа. Гэвч гэрээний дагуу бол судалгааны ажил бүрэн дууссан цагт л үр дүнг нь мэдээлэх ёстой юм. Гэхдээ судалгааны явцад зарим үр дүнг нь мэдээлэх хэрэгтэй гэсэн Ёшидагийн саналыг Очир найрсгаар хүлээн авч, гэрэл зургийн хамт нийтлэхээр санал нийлсэн билээ. Ийнхүү Япон Монголын хамтарсан судалгааны багийн ажлын үр дүнгийн нэгээхэн хэсэг нь Васэда Их Сургуулийн Монгол судлалын төвийн анхны сэтгүүлд хэвлэгдэж байгаа нь энэ.

## 1. Үйсэн дээр монгол хэлээр бичсэн дурсгалыг судалсан байдал —Үйсэн дээрх бичгийн дурсгал, түүний тархалт

Одоогоор мэдэгдэж буй үйсэн дээр монгол бичгээр бичсэн хамгийн эртний дурсгал бол 1930 онд Волга мөрний баруун эргээс олдсон "Алтан ордны үйсэн дээрх бичиг" билээ. XIII-р зууны үеийн энэхүү шүлэглэсэн зохиолын судалгааны эхлэлийг Н. Поппе тавьж (Поппе Н. Н. "Золотоордынская рукописи на бересте." *Советское востоковедение*. 2(1941): 81–136), түүний дараа ч судалгаа олноороо хийгдэн хэвлэгдсэн. 1970 онд монгол хэлээр бичсэн хамгийн том дурсгал Узбекистаны Алмалыкаас олджээ. "Найман гэгээн"-ийг монгол хэлээр тэмдэглэсэн XVI зууны үеийн бичиг гэгддэг энэхүү дурсгалын талаарх судалгааг Таубэ хийн, 1992 онд хэвлэн гаргасан байна. (Taube. M. *Mongolische Birkenrinden-Fragmente in Taschkent.* Ural-Altäische Jahrbücher. Neue Folge 11(1992)Д152–155). Таубэгийн судалгаанд эх текст, гэрэл зураг нь байхгүй учир нарийн нотлон хэлэх боломжгүй боловч, хэрэв зээ уг судалгаа эндүүгүй бол энэхүү сурвалж нь Төв Азийн бурханы шашны хүрээнд өргөн дэлгэрсэн "Найман гэгээн" зэрэг зохиол нь аль хэдийн лалын шашинд орсон XVI зууны Узбекистанд монгол хэлээр хуулбарлагдан бичигддэг байсан болохын бодит жишээ болно. Тухайн үеийн, тус нутаг дахь бурханы шашин шүтлэгийн бодит төрхийг өгүүлснээрээ ихээхэн сонирхол татаж байгаа ч харамсалтай нь Узбекистаны сурвалжийн талаар дээрхээс өөр зүйл олж мэдсэнгүй.

1970 онд археологич Х. Пэрлээ, Е. В. Шавкунов нар Монголын төв хэсэгт орших Булган аймгийн Дашинчилэн сумын Хар Бухын балгас хэмээх түүхэн суврагын хавиас 1000 гаруй хэрчим үйсэн бичгийн дурсгалыг олжээ. Эдгээр нь бараг бүгд монгол болон төвд бичгээр бичигдсэн XVI-XVII зууны үеийн сурвалж бөгөөд агуулга нь бурхны шашны судар ном, залбирлын болоод иргэний шүтлэгийн шүлэг, хууль цаазын зүйлс байдаг. Тухайн үеийн монголын хуулийн тогтолцоо, нийгмийн байгууллыг тод томруун дамжуулсан ховор сонин, ялангуяа XVI-XVII зууны үеийн халх монголын олон хууль цаазыг (энэ хэсгийг Японд "үйсэн дээрх хууль цаазын бичиг" хэмээн товчлон тэмдэглэдэг) багтааснаараа нэлээд чухал болох энэхүү сурвалжийн анхны судалгааг Х. Пэрлээ хийсэн бөгөөд (Х. Пэрлээ. "Халхын шинэ олдсон цааз-Эрхэмжийн дурсгалт бичиг.": Тэргүүн дэвтэр. *Monumenta Historica* 6-1(1974)Д1-139. УБ: ШУАХ), дараа нь Х. Фүтаки тайлбар орчуулга, үйсэн дээрх хууль цаазын бичгийн цагийн байдал, хуулийн тогтолцоо болон уг сурвалжид тулгуурласан халх монголын нийгмийн байгууллын талаарх судалгаанаас бүтсэн бүтээлээ хэвлүүлжээ. (二木博史 「訳注訳注白樺法典 (I)」 『遊牧社会史探究』 50 (1977) : 10-19. ; 「訳注白樺法典 (II) - (III)」 『モンゴル研究』 12 (1981) : 50-63, 14 (1983) : 12-27. ; 「白樺法典について」 『アジア・アフリカ言語文化研究』 21 (1981) : 49-73).

Мөн саяхан А. Насилов латин галиг, монгол бичгийн текст, орос хэлээрх тайлбар орчуулга, уг сурвалжид тулгуурласан монголын хуулийн тогтолцооны түүхэн судалгаа зэргээс бүрдсэн нэгэн сэдэвт судалгааны бүтээлээ хэвлүүлсэн (Насилов, А. Д. *Восемьнадцать степных законов: Памятник монгольского права XVI-XVII вв.* СПб: Петербургское Востоковедение, 2002) бөгөөд латин галиг, монгол бичгийн текст нь дээр өгүүлсэн Х. Пэрлээгийн номонд тулгуурласан байна.

Х. Пэрлээ "Эрхэмжийн дурсгалт бичиг"-ээс гадна өөр 2 сурвалжийн судалгаа (Х. Пэрлээ. "XVII-р зууны эхэн мөчлөгийн монгол яруу найргийн үйсэнд бичсэн хоёр зүйл: *Studia Mongolica* III (11)-7(1976)Д125-151. УБ: ШУАХ) болон нэг тэмдэглэл (Х. Пэрлээ. "Үйсэнд бичсэн цаазын өөдөс": *Studia Mongolica* IV (12)-10(1976):291-293. УБ: ШУАХ) зэрэг холбогдох судалгааг хийсэн боловч уг үйсэн дээрх сурвалжийг бүрэн судалж амжсангүй.

1993 онд дээрх Хар Бухын балгасын сурвалжийг сэргээн засварлахаар Бонны Их Сургуулийн Төв Азийн Судлалын Хүрээлэнд хүргэж, К. Сагастер, Е. Киодо нар судлах болсноор

сурвалжийн судалгаанд томоохон ахиц гарсан билээ. Энэхүү судалгааны эхний үр дүн 1995 онд гарч (Chiodo, E. & K. Sagaster. "The Mongolian and Tibetan Manuscripts on Birch Bark from *Harbyxyn Balgas*: A Preliminary Description." Zentralasitische Studien 25(1995):28-41), 2000 онд гол судалгааны нэг болох сурвалжийн хэлний онцлог, латин галиг, тайлбар орчуулга, үгийн индекс, эхийн гэрэл зургийг багтаасан том боть хэвлэгдсэн билээ (Chiodo, E. "The Mongolian Manuscripts on Birch Bark from *Harbyxyn Balgas* in the Collection of the Mongolian Academy of Sciences. Part 1. Asiatische Forschungen 137. Wiesbaden: Harrassowitz Verlag, 2000). Энэ ботид 1000 хүрэх үйсэн сурвалж бичгийн 240 гаруй нь багтсан бөгөөд хууль цаазын хэсгийг оролцуулан үлдсэн хэсгийг нь дараа хэвлүүлэхээр болжээ.

Эдгээрээс гадна Х. Пэрлээгийн дурьдсанаар, Монгол улсын Архангай аймаг Тариат сумын архивт газрын зурхайг тэмдэглэсэн үйсэн дээрх бичиг, Копенгагены хааны номын санд "үйсэн сахиус" хадгалагдаж буй талаар ч мэдээ байна. Мөн 2004 оны 3 сард Иноүэ, Очир, Алтанзаяа нар Монгол улсын Төв Номын санд 4 хэрчим үйсэн бичгийн дурсгал байгааг олж мэдсэн байна. Түүнчлэн Очирын хэлснээр бол, монголд үйсэн дээрх бичгийг хадгалж буй хувь хүн ч нэлээд байдаг аж. Харин Өвөр монголын нутгаас үйсэн бичгийн дурсгал олдсон гэх мэдээ алга.

Дээрх судалгаанууд дээр үндэслэн, XIII-XVII, XVIII-р зууныг хамрах үйсэн бичгийн дурсгалууд нь Волга мөрнөөс Монголын төв хэсэг хүртэл тархжээ гэж үзэхэд ташаа болохгүй болов уу. Харин одоо буй үйсэн бичгийн дурсгалуудын нийт тоог таамаглан гаргах нь нэлээд бэрхшээлтэй байна.

## 2. Хусны үйсний хэрэглээ

2004 оны 3 сард Иноүэ, Очир, Алтанзаяа нар Улаанбаатарын Увс болон Булган аймгийн харьяат иргэдтэй уулзан хялбар судалгааг авчээ. Судалгааны үр дүнд одоо үйсийг боловсруулан цаасны оронд хэрэглэх монгол хүн байхгүй болох нь нотлогдож, үйсийг боловсруулах арга, түүнийг хэрэглэх болсон эдийн болоод оюуны хэрэгцээ шаардлага нь бүрхэг хэвээр үлджээ.

Энэ өгүүлэлд гарч буй үйсний байдлыг ажиглан үзвэл, хэрчим бүрийн зузаан нь өөр өөр, бүр хэт нимгэн заримыг нь хэд хэд давхарласан нь ч байна. Эдгээр нимгэн үйс нь өөрөө хууларсан чигээрээ байна уу, эсвэл бүдүүн үйсийг хуулан авч нимгэн болтол нь боловсруулав уу гэдэг нь дээр өгүүлсэнчлэн одоогоор тодорхой бус байна. К. Сагастер, Е. Киодо нар судалгаандаа үйсийг хэрэглэх болсон шалтгааныг монголын хойд нутагт цаас ховор болоод үнэтэй байсан, энэ нутагт хус ихээр ургадаг байсан, модыг тахин шүтдэг монголчууд (ялангуяа буриадууд) хусыг ариун нандин зүйл хэмээн боддог байсан зэрэгтэй холбон тайлбарласан байдаг (Chiodo, E. & K. Sagaster "The Mongolian and Tibetan Manuscripts... ." pp.30-31). Дээр өгүүлсэн хялбар судалгаанд ч үүнтэй төстэй зүйл гарч байсан боловч энэхүү үндэслэл нь таамаг төдийгөөс хэтрэхгүй байна.

Ер нь зөвхөн монгол хүн л үйсийг боловсруулж хэрэглээд байсан уу гэвэл үгүй. Эвенкүүд, Орчөнчууд, Дагуурууд ч хусны үйсийг боловсруулж аж төрөлдөө хэрэглэн, хээ хуар зурдаг байсан гэх мэдээ бий (蘇日台著、岡田陽一訳「中国大興安嶺の狩猟民族の樺樹皮文化」『自然と文化』71(2003) : 4-15 ; 岡田陽一訳「中国大興安嶺の狩猟民族の樺樹皮器物の装飾装飾文様図録」『自然と文化』71(2003) : 16-26). Мөн XIII-р зууны үеийн дурсгал олдсон ("Алтан ордны үйсэн дээрх бичиг") Волга мөрнөөс төдий л холгүй Новгородод XIII-XV-р зуунд бичиг хэрэгт үйсийг ихээр хэрэглэдэг байсан гэх мэдээ байна (V.L.ヤーニン著、松木栄三訳『白樺の手紙を送りました : ロシア中世都市の歴史と日常生活』、山川出版社、2001). "Алтан ордны үйсэн дээрх бичиг" болон Новгород хавийн үйсэн бичгийн хооронд ямар нэг холбоо хамаарал байж болох мэт санагдана. Дээрхээс харвал, монгол хэлээр буулган бичих материал болгон хэрэглэж байсан хусны үйсний талаар судлахдаа дан ганц монголд буй хустай холбоотой ардын урлаг сэлтийг судлах гэлгүй, орос, дундад ази, сибирь, хятадын хойд зах хавийн нутгийг ч хамруулах хэрэгтэй. Түүнчлэн цаасны оронд хэрэглэж байсан үйсийг боловсруулж ирсэн технологийг нь илрүүлэхийн тулд чамгүй хичээл, чармайлт шаардлагатай нь ч дамжиггүй.

### 3. Өгүүлэлд гарч буй үйсэн сурвалжийн тухайд

—Үйсний байдал, сэргээн засч, цэгцлэх явцад гарсан асуудлууд—

Засварлалтаас гарсан үйснүүдийг ажиглавал, олдсон үед нь дугаарласан (цаашид цэгцэлсэн дугаар гэнэ)—аар II-3-1-1-ээс II-3-1-8 хүртэл нийт 8 хэсэгт, нийтлэг хэдэн онцлог байна. Өөрөөр хэлбэл, хэрчмийн гол хэсэг нь овойсон, голын тэр хэсэгт үсэг бичигдээгүй, харин олон тооны жижиг нүхнүүд байгаа нь ажиглагдана. Эдгээр 8 хэсгийн ерөнхий байдал, үгийн залгаа холбоог харвал, II-3-1-2 болон 3, II-3-1-6 болон 7 нь нэг хэсэг болох нь ойлгогдож, нийлүүлэн холбосны дүнд 8 хэсэг маань нийт 6 хэсэг болсон бөгөөд нийлүүлэн холбосон хэрчмүүдээ урьдчилсан байдлаар II-3-1-2+3, II-3-1-6+7 гэж дугаарласан. Хэрчмийн цэгцэлсэн дугаарт ар өвөр талыг ялган тэмдэглээгүй байсан тул, Японы тал дээр нь нэмэн, "а" (=өвөр), "б" (=ар) гэж дугаарласан болно.

Текстийг уншиж үзэхэд, голын овойсон хэсгийн зүүн болон баруун талд буй бичвэрүүд нь дүрмийнхээ хувьд ч, утгынхаа хувьд ч хоорондоо авцалдахгүй, бичвэрийн эхлэл болон төгсгөл нь ихэнхдээ ар талдаа юм уу, өөр хэрчим дээр бичигдсэн болох нь илэрхий болсон юм. Үүгээр нь дээрх 6 хэсгийг нэг нэгээр нь давхарлан нугалж, голоор нь жижиг нүх гарган цоолж, үдээсээр (малын үс ноосоор хийсэн) үдэж гэж таамаглаж байна.

Үйсний байдлаас үүдэн, хэрчмийн зүүн баруун талыг ялгахын тулд цэгцэлсэн дугаар болон нэмэлт дугаарын ард "|1" (=зүүн), "|2" (=баруун) гэж дугаарласан болно. Жишээлбэл, II-3-1-1a|1 гэж байвал, II-3-1-1 нь цэгцэлсэн дугаар, "а" нь өвөр, "|1" нь хэрчмийн зүүн тал гэсэн илэрхийлэл болно. (Доор бүх хэрчимд нийтлэг байгаа "II-3-1" гэсэн хэсгийг хураангуйлсан). Тэгээд хэрэв энэ нь нугалж үдсэн байсан гэж үзвэл, бичвэр нь 16|2→1a|1→26|2→2a|1→2a|2→26|1→1a|2→16|1 гэсэн дарааллаар үргэлжлэх юм. Харин 2+3 цэгцэлсэн дугаартай хэрчим нь засварлалтын явцад гүйцэд салаагүйтэй холбогдон 2+3a нүүрний зүүн талын хуулраагүй хэсэгт үсэг бичигдсэн байж болох магадлалтай. Одоогоор дахин Гэнкёожи судалгааны төвд засварлалт хийлгэх боломжийг судалж байгаа бөгөөд одоо байгаа 2+3 хэрчмээс дахин нэг хэрчим гарах нөхцөлийг бодолцон шинэ хэрчмийг ч дугаарлахаар боллоо. 2+36'|1 талд бичвэр байгаа тул, хуулраагүй хэрчмийн дотор тал болох 2+3a'|1, 2+36'|2 -д ч бичвэр байхыг үгүйсгэх аргагүй. Засварлалтын үр дүн хэрхэхээс шалтгаалж, эх бичвэрийн япон орчуулгад ч зарим нэг өөрчлөлт гарч болохыг урьдчилан мэдэгдмээр байна. Мөн дээрх хуулраагүй үлдсэн хэрчмээс үүдэн, цэгцэлсэн дугаар ч нэлээн замбараагүй болсон тул самуурлаас зайлсхийн ахин шинээр дугаарлахаар боллоо. Цэгцэлсэн дугаар болон шинэ дугаарын харьцуулалт, бичвэр байгаа эсэх (? нь хуулраагүй үлдсэн хэрчим), нугалсан номын хуудасны тоо зэргийг доорхи хүснэгтээр харуулсан бөгөөд цаашид шинэ дугаарыг хуудасны тоотой хамт хэрэглэхээр болсон.

Цэгцэлсэн дугаар	Шинэ дугаар	Бичвэр	Хуудас	46 2	3r:b	○	5	6+7a 2	5v:b	○	19
2+3a 1	1r:a	X	28	4a 1	3v:a	○	6	8a 1	6r:a	○	18
2+3a 2	1r:b	○	1	4a 2	3v:b	○	23	8a 2	6r:b	○	11
2+3a' 1	1v:a	?	2	5a 1	4r:a	○	22	86 1	6v:a	○	12
2+3a' 2	1v:b	X	27	5a 2	4r:b	○	7	86 2	6v:b	○	17
2+36' 1	2r:a	○	26	56 1	4v:a	○	8	16 1	7r:a	○	16
2+36' 2	2r:b	?	3	56 2	4v:b	○	21	16 2	7r:b	○	13
2+36 1	2v:a	○	4	6+76 1	5r:a	○	20	1a 1	7v:a	○	14
2+36 2	2v:b	○	25	6+76 2	5r:b	○	9	1a 2	7v:b	○	15
46 1	3r:a	○	24	6+7a 1	5v:a	○	10				

#### 4. Текстин онцлогийн тухайд

Дор текстин хэлбэр болон агуулга, хэлний онцлог, бичигдсэн болон хуулбарлагдсан он цагийн талаар судалсан болно.

#### 4-1. Хэлбэр болон агуулга

Бичвэрийн хэлбэрийн хувьд тус бүр нь 4 мөртэй 28 бэдгийг толгой холбон, зарим газар сүүл холбон бичсэн.

Агуулгын хувьд, 1-р бадгаас 11-р бадга хүртэл өргөлийн шүлэг, 12-р бадгаас 23-р бадга хүртэл сургаалын шүлэг, 24-р бадгаас 28-р бадга хүртэл залбирлын шүлэг, төгсгөлийн үг гэсэн бүтэцтэй байна.

Өргөлийн шүлэгт, Шигамуни → Оточ багш → Амитаба → Амитабагийн хувьилгаан гэгддэг Энэтхэгийн мэргэн Атша(982-1054) → Атшагийн Төвд шавь болох Домтон(1005-1064) → Домтоны шашны үрсгэлийг XIV-р зуунд сэргээн дэлгэрүүлсэн Зонхов (1357-1419) → өөрийн лам(багш) гэсэн дарааллаар тэдгээрийг мэтгэн дүүллсэн байна.

Сургаалын шүлэгт, хойд насны аялалд гарахын цагт эд хөрөнгө, нөхөр садан салгийг орхиод яваххаас өөр аргагүй тул, хүсэл тачаал, уур хилигт тэвчин, амьд ахуйдаа ламд сүслэн буян хураахын чухлыг өгүүлсэн бол залбирлын шүлэгт өөрийн лам багшаас сахин хамгаалахыг залбирсан гуйсан байна.

Монгол хэлээрх бүрхэны шашны зохиол нь төвд судар номын орчуулгатай байх нь олонтой. Гэвч энэхүү шүлэглэсэн зохиол нь монгол хэлээр толгой холбон бичигдсэн хараал, төвд судар номын монгол орчуулга бүс, угаас монгол хэлээр бичигдсэн байна гэж бодогдож байна. Тэрчлэн бүрхэны сургаалыг энгийн үгээр, илэрхий аргаар зориулан бичсэн байх тул, монголын жирийн нэг гэр бүлийн өглөөний уншлагын ном байсан байж болох тагтай байна.

#### 4-2. Хэлний онцлог

Энэхүү үйсэн бичгийн дүрсгалын хэлний онцлог нь Хайсигийн судалсан Олон сүмийн бичиг, Киодогийн судалж буй Хар Бухын багласын сурвалжтай үндсэн дээ таарч байна (Heisig, W. Die mongolischen Handschriften-Keste aus Olon sume Imere Mongolei (16-17 Jhd.) Asiatische Forschungen 46, Wiesbaden: Otto Harrassowitz, 1976, pp. 561-576; Chido, E. "The Mongolian Manuscripts on Birch Bark from Kharyul Balgas...", pp. 21-35). Ингээд Хайсигийн авч үзсэнээр энэхүү сурвалжийн хэлний онцлогийг томилоё.

#### 4-2-1. Үсгийн хэлбэр

Сурвалжийн бичиг нь зурлагыг товчлолгүй хичээнгүйлэн бичигдсэн байх бөгөөд хулсан үзэг хар бэхийг хэрэглэжээ. 4-2-д энэ дүрсгалын хэлний онцлог нь Олон сүмийн бичиг болон Хар Бухын багласын сурвалжтай үндсэн дээ таарч байна гэж дурдсан боловч үсгийн хэлбэрийнхээ хувьд гол ялгаарх нэгэн зүйл байна. Энэ нь зарим газарт төд бичгийг хэрэглэсэн явдал болно. Төд бичиг нь баруун монголын ойрд аялгуу сайтар ялган тэмдэглэхийн тулд Ойрдын гэгээн Зая бандид Намхайжамц 1648 онд монгол бичгийг сайжруулан зохиосон бичиг билээ. Энэ нь дор гарах хуулбарлагдсан он цагийг таамаглахад нэгэн барьц болохын хамт дээрх хэлбэрийн онцлогтой нийлэн сурвалжийн бусад үйсэн дүрсгалаас ялгаарх томоохон онцлог тал нь болно. Ингээд монгол бичгийн хэлбэрийн онцлогийг харуулсан зарим нэг жишээ болон төд бичгийг хэрэглэсэн байдлыг талаар тайлбарлая.

#### 4-2-1-1. Монгол бичгийн хэлбэрийн онцлог

① Үгийн эхний q/y (x) нь а ( ) үсэг шиг бичигдсэн жишээ:

урбан (06:10), гарму (14:10), яатм (20:10)

② э нь үгийн дунд j-тэй адил хэлбэртэй бичигдсэн жишээ:

stülyan (04:06), tegüskejü (04:06)

- ③ у болон үгийн эхний j адил хэлбэртэй бичигдсэн жишээ:  
yirtinčü (01:05), jalbarimui (04:04), jayayan (17:01)
- ④ үгийн эцсийн m нь r-тэй адил хэлбэртэй бичигдсэн жишээ:  
nom (14:09), lam\_a (15:06)
- ⑤ цацлага нь үгийн эцсийн i (хумс) —тэй адил хэлбэртэй бичигдсэн жишээ:  
bey\_e (05:02), tesküy\_e (21:04)
- ⑥ үгийн эцсийн s нь уйгар үсгийн z-р бичигдсэн жишээ: уг сурвалжид s нь бүгд z-р бичигдсэн байна. Ийм s-г š гэж тэмдэглэлээ.  
abiyaš (23:11,24:11), kromuruš\_ta (08:10), nisvaniš (25:05), tegš (07:11,10:06), üileš(25:09)

#### 4-2-1-2. Тод үсгийн хэрэглээний тухайд

Тод үсэг нь монгол бичигт байдаг хоёр авиаг нэг дүрсээр тэмдэглэдэг байдлаас зайлсхийлэн, үсгийн хэлбэрийг өөрчилж, цэг тэмдэг нэмэх зэргээр ялгаснаараа нэлээд онцлогтой. Ингэснээр аль нь ямар үсэг болох нь төвөггүй ялгагдана. Доор сурвалжид хэрэглэгдсэн бүх тод үсгийн хэлбэрийг гарган тавьж, дөрвөлжинд (□) оруулан тайлбар хийлээ.

- ① урт эгшгийг заадаг тэмдэг болох "удаан" (зэрэгцүүлэн татсан зураас)<sup>1</sup>.  
qaju (Mon. qaju. 23:10), qosun (Mon. qoyusun. 16:01)
- ② богино о эгшгийг тэмдэглэдэг "дөрвөлжин гэдэс" (гэдсийг дөрвөлжилсэн хэлбэр)  
boydo (Mon. boyda. 11:03, 21:07, 22:05, 23:07, 24:05, 26:03)
- ※ 11:03-с бусад тохиолдолд хоёрдугаар үеийн о эгшиг нь дөрвөлжин байгаа бөгөөд 11:03-д сайн ялгагдахгүй байна.
  - ※ Нэгдүгээр үеийн о эгшгийн тухайд ч дөрвөлжин байгаа эсэх нь ялгахад хүндрэлтэй, 11:03, 21:07, 22:05-д дөрвөлжин гэдэс байж магадгүй.  
boqdo (Mon. boyda. 25:01)
  - ※ Хоёрдугаар үеийн о эгшиг нь дөрвөлжин гэдэс.  
soyirqo (Mon. soyirq\_a. 24:05, 25:01, 26:03)
  - ※ 22:04 болон 23:06-д soyirqa юмуу soyirqo гэж уншихаар SWYYRXW гэсэн хэлбэртэй байгаа бөгөөд сүүлийн W нь хоюуланд нь дөрвөлжин биш байсан тул, soyirqa гэж галиглалаа.
- ③ богино ö эгшгийг тэмдэглэдэг "дөрвөлжин гэдэс+өөдөө татсан өргөс"  
zögüyin (Mon. zögei — yin. 20:05)
- ④ богино ü эгшгийг тэмдэглэдэг "моголцог гэдэс" (Мон бичгийн үгийн дундах гэдэстэй ижил) болон "хөндий гэдэс" (Монгол бичгийн үгийн эцсийн гэдэстэй ижил)  
čüb (Mon. čöb. 09:03)
- ※ CWB гэсэн хэлбэртэй, монгол бичгээр čöb, тод бичгээр cöb болно. Гэвч монгол бичгийн töb —г, тод бичгээр tüb гэж бичдэг жишээ байгаа тул (Krueger, J.R. *Materials for an Oirat Mongolian to English Citation Dictionary*. Part 1-3. Bloomington, Ind.: Mongolia Society, 1978 — 1984), монгол бичгээрх čöb —г, тод бичгээр cüb ч гэж бичдэг байсан гэж хэлж болох болов уу.  
tümür (Mon. temür. 21:01)
  - ※ TWMWR гэсэн хэлбэртэй. Тод бичигт голдуу tömör эсвэл tömür гэх боловч tümür гэсэн нь ч харагддаг (Krueger, J.R. *Materials for an Oirat Mongolian...* .)  
ülü (Mon. ülü. 21:03)
- ⑤ z<sup>2</sup> гийгүүлэгчийг тэмдэглэх "чацуу эрүү" (Монгол бичгийн č —тэй ижил)  
zürüken (Mon. zürüken. 04:03), zögüyin (Mon. zögei. 20:25)

<sup>1</sup> "Ц.Шагдарсүрэн. Монгол үсэг зүй : Тэргүүн дэвтэр. УБ. ШУАХ. 1981." номоос тод үсгийн нэр дуудлагыг ишлэлээ.

<sup>2</sup> Тод бичигт "чацуу эрүү" өн ард i эгшиг орж байвал ji гэж галигладаг.



※ Дээрх хоёр жишээн дэх “чацуу эрүү” –ний зүүн доод буланд баруун тийш татсан богино зураас байна. Энэ нь с<sup>3</sup> гийгүүлэгчийг тэмдэглэх “дутуу эрүү” (Монгол бичгийн j–тэй ижил)–тэй андуурсныгаа зориуд нүдэнд тусахуйцаар ийнхүү тэмдэглэжээ гэж бодогдохоор байна.

⑥ Гийгүүлэгчийн өмнөх q–г тэмдэглэх “хүчлэг”

boqdo (Mon. boyda. 25:01), ilayu=qsad (Mon. ilayuysad. 08:04), baqtay\_a\_ba (Mon. baytayaba. 25:03)

Дээрх жишээнүүд нь тод бичиг хэрэглэсэн гэж хэлэхэд бараг эндүүрэл болохгүй. Харин доорх хоёр хэлбэр нь тод бичиг хэрэглэсэн эсэх нь эргэлзээтэй байна.

Сурвалжид үгийн эцсийн s нь бүгд ś–р бичигдсэн байгаа нь тод үсгийн нөлөө байж магадгүй. Үгийн дунд ордог d (d гэж галиглав) үгийн эцэст гарч буй нь сонгодог монгол бичгийн хэлний үе болон түүний өмнөх үеийн сурвалжид ч харагддаг тул шууд тод бичгийн хэлбэр гэж үзэж боломгүй байна.

balmad (05:05), ed (13:04,15:08), maqand (13:05), -nuyud (18:02), ked (20:07), nijeged (22:02), nökud (22:01, 23:04)

4–2–2. Зөв бичих дүрмийн тухайд

4–2–2–1. п, γ, ś –г онцлон ялгахдаа бүгдэд нь бус тухайн үсэг нэг бүртээ ц, ү, ś гэхчилэн онцлох тэмдэг тавьлаа.

арγa (21:06), dani (20:06), nai (14:07), qanilan (13:08,14:05), biśiren (11:04)

4–2–2–2. d ба t–г ялгаагүй жишээ.

① Үгийн дунд гийгүүлэгчийн өмнө орсон d (W')–г эгшгийн өмнө ордог d (D)–р бичсэн жишээ: Уг d–г d гэж тэмдэглэлээ.

jedkedi (07:02), odqui (17:02), sedkijü (19:03), yegüdkeki (21:08), tiüdker (25:04)

② Үгийн дунд эгшгийн өмнө орсон t (D)–г үгийн эхний t (T)–р бичсэн жишээ: Уг t–г t гэж тэмдэглэлээ.

bayatur (05:06), časutu (07:08), qoyitu (12:01)

③ Үгийн эцэст орсон d (W')–г эгшгийн өмнө ордог d (D)–р бичсэн жишээ: Уг d–г мөн d гэж тэмдэглэлээ.

burqad (01:03), ked (20:07)

※ ed (13:04) бол уламжлалт бичлэг.

④ d, t–р эхэлсэн нөхцөлүүд нь үг холбох дүрмээс гажсан жишээ: мөн d, t гэж тэмдэглэлээ.

galab-dur (04:05), jarliy-du (05:04)

Gf. galab-tur (11:06), jarliy-tu (10:11)

4–2–2–3. Хоёрдугаар үеийн ü эгшиг нь шүдтэй бичигдсэн жишээ ; ü гэж тэмдэглэлээ.

lüge (12:05) зөвхөн энэ жишээ.

4–2–2–4. g эр үгэнд хэрэглэгдсэн жишээ:

oyugulugči (04:03, 09:07), abtagsan (16:05), janggidugsan (23:09)

※ γ–н хувьд иймэрхүү дүрмийн бус зүйл ажиглагдсангүй.

4–2–2–5. Авиа сэлгэлт

Уг эхэд буй maqand (16:05) гэсэн үгийг Mon. maqabud<Skt. mahābhūta –г гэж тайлсан бөгөөд гарт буй халимаг хэлний болон ойрд аялгууны тольноос maqanud (Tod.maxanud) гэсэн үгийг олсонгүй. Энэ үгийг бусад бичвэрүүдтэй харьцуулан m, b–н авиа сэлгэлт гэж үзэж болно. Мөн түүнээс гадна

<sup>3</sup> Тод бичигт “дутуу эрүү” өн ард i эгшиг орж байвал či гэж галигладаг.

maqan (Mon. miqan, Tod.maxan)-нд олон тооны ) –ud дагавар залгасан хэлбэр, эсвэл maqanud–н n нь m байсан бөгөөд бичихдээ эврийг нь хаячихжээ гэж үзэж ч болох юм.

#### 4-2-2-6. Үгийг салгаж бичсэн жишээ.

① хоёр мөр дамнан бичигдсэн жишээ: alaysayul=un(17:04-05) мэт жишээ олон байна.

② дүрэм бус салгаж бичсэн жишээ

čiyul\_un (Mon. čiyulun 12:06)

※ un, ün–г залгаж бичсэн жишээ сонгодог бичгийн хэлний үе болон түүний өмнөх үеийн сурвалжид ч цөөнгүй харагддаг.

nab\_či (Mon. nabči. 14:03) < org. nab'či?

sitü\_kü (Mon. sitükü. 17:03) < org. sitü=kü?

baqtay\_a\_ba (Mon. baytayaba. 25:03) < org. baqtay\_a=ba?

※ дээрх гурван жишээний тухайд, бичээч анхны эхдээ хоёр мөр дамнан бичигдсэн байсан үгийг (nab\_či, sitü\_kü, baqtay\_a\_ba) засалгүйгээр шууд хуулан бичсэнээс үүсчээ гэж ч бодогдохоор байна.

#### 4-2-2-7. Нөхцөлүүдийг залган бичсэн жишээ.

Энэ эхэд нөхцөлүүдийг өмнөх үгтэй нь залган бичсэн зүйл нэлээд байгаа бөгөөд эдгээрийг доор тусад нь тайлбарласан болно.

#### 4-2-2-8. Эртний хэлбэр.

ebečin (ebedčin. 06:03), ora (oru. 12:02), tabar (tavar. 15:09), ked (ken-ий олон тоо. 14:03) г.м

#### 4-2-2-9. Ярианы хэлний нөлөө орсон хэлбэр.

yančakü (yačakü. 01:05, 07:08, 08:04), jaran (jiran. 01:09), önggü (öngge. 15:10, 06:11), genete (genedte. 16:02), ilete (iledte. 21:10)

#### 4-2-2-10. Харь үг хэллэг.

ridi (<Skt.ṛiddhi. 07:06), kšan (<Skt. kṣana. 06:05,07:02), sudadan (<Skt. Suddhodana. 04:09), sükavadi (<Skt.sukhāvati 06:08), bayidur\_yian(<Skt. vaidūrya. 05:10), sadu (<Skt.sādhu 26:06)

kromuruš\_ta (=qormusta<Uig.xormuzta<Sogd.xwrmzt'.08:10), nisvaniš (<Uig. nizvani<Sogd.nyzB'ny. 25:05), edgü (<Uig.edgü. 26:06),

brom ston (<Tib. 'brom ston 08:11), jongga\_ba (<Tib.tsong kha pa. 09:10. δ-г ova гэж бичсэн байгаа бөгөөд энэ нь уг төвд үсгийн монгол бичгээрх галиг)

#### 4-2-3. Хэлбэр

Доор тийн ялгалын нөхцөл, олон тооны нөхцөл, үйлт нэрийн нөхцөлүүдийг ажиглалаа.

#### 4-2-3-1. Харьяалахын тийн ялгал:

Харьяалахын тийн ялгалын хэрэглээ нь орчин цагийн зөв бичих зүйгээс ялгарах зүйлгүй, дүрмийн дагуу залган бичсэн доорх хэлбэртэй байна.

–u –н жишээ: toyusun |u (18:07)

–un/ün –н жишээ: oduysad |un (11:01), üköl |ün (12:06), ulus |un (18:04)

–yin –н жишээ: busu |yin (07:02), öglige |yin (16:07), qoru |yin (06:03), siru |yin (06:11), tamu |yin (17:07), usa |yin (04:08), zöğü |yin (20:05. cf. Kalm. зөг)

–in –н жишээ: dalay |in (<dalai-yin. 07:10, 20:03, 25:02), oruy |in (<orui-yin. 01:06, 07:09)

※ nigülesküyin (01:07) нь nigüleskü-yin үү, эсвэл nigüleskü-yin үү, arilyaquyin (21:06) нь arilyaquy-in уу, эсвэл arilyaqu-yin уу гэдэг нь тодорхой бус байна.

#### 4-2-3-2. Заахын тийн ялгал:

Заахын тийн ялгал ч мөн харьяалахын тийн ялгалын адил орчин цагийн зөв бичих зүйгээс

ялгаагүй боловч залгуулан бичсэн хэлбэртэй байна.

nomuud|i (05:03), jedked|i (07:02), бүкүн|i (10:09), egüden|i (10:11), egün|i (12:03), Үар|i (16:01), nigül|i (16:10, 19:06, 20:09), bidan|i (20:06), tegün|i (21:05),

**4-2-3-3. Өгөх оршихын тийн ялгал:**

Өгөх оршихын тийн ялгал нь tur/tür; dur/dür; a; da; тауан гэсэн хэлбэртэй байгаа бөгөөд дүрмээс гажсан доорх жишээ цөөнгүй байна.

galab-dur, aman-tur, blam\_a-tur, burqan-tur, dolgiyan-tur, erdeni-tür, Үal-tur, jayayan-tur, jobayaqui-tur, jobalang-tur, nom-tur, odqui-tur, orçilang-tur, tala-tur

Мөн жаура-tu<sup>1</sup> da (24:01) гэсэн нийлсэн хэлбэр ч байна.

**4-2-3-4. Гарахын тийн ялгал:**

Гарахын тийн ялгалын —аца/есе нөхцөлүүд нь дүрмийн дагуу бичигдсэн байна.

**4-2-3-5. Үйлдэхийн тийн ялгал:**

Үйлдэхийн тийн ялгалын —бар/бер; ияр/ийер нөхцөлүүд ч дүрмийн дагуу байна.

**4-2-3-6. Хамтарахын тийн ялгал:**

Хамтарахын тийн ялгалын —луя/lüge-н хэлбэр байна.

Энд önggü — luу\_a (05:10~06:01), selte-lüge (12:05) гэсэн хоёр жишээг дурдаад орхиё. Эхнийх нь үг холбох дүрмийг зөрчсөн сонгодог бичгийн хэлний үе болон түүний өмнөх үеийн монгол сурвалжид цөөнгүй харагддаг хэлбэр. Сүүлийнх нь ü-г шүдтэй бичсэн хэлбэр байна. Үүнийг ü гэж тэмдэглэлээ.

**4-2-3-7. Хамаатуулах iуан-ы хэлбэр:**

Хамаатуулахын хоёр хэлбэр гарч байгаагийн нэгийг нь өгөх оршихын тийн ялгалтай залгуулан бичжээ.

blam\_a-tur|iуан (11:03)

**4-2-3-8. Олон тооны хэлбэр:**

Олон тооны хэлбэр нь ① n, r-р төгссөн үгэнд d залгах ② s-г шууд залган бичих ③ нууud, üd, uud нөхцөлөөр холбох гэсэн гурван аргаар бүтсэн байна.

① ked (ken 20:07), sadud (sadun. 12:09), burqad (burqan. 01:03), nökiid (nökiir.25:04), jedkedi (jedker. 07:02)

② erdeni|s;ün (07:10)

③ amitan — нууud ( 01:09), tabar — нууud ( 13:04), tib — üd ( 08:03), nom|iуud|i ( 08:03)

※ Орчин цагийн зөв бичих зүйд -нууud/nügiid-г эгшгээр юм уу n-р төгссөн үгэнд залгадаг. tabar — нууud гэхчлэн бичих нь дүрэм бус бөгөөд, эгшгээр төгссөн эсэхээс нь хамааралгүй нууud/nügiid —г хэрэглэсэн нь цөөнгүй байна.

※ —uud нь ярианы хэлний хэлбэр.

**4-2-3-9. Үйлт нэрийн хэлбэр**

